

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХАЯГ

Уурхай:

Шарын Гол ХК
Монгол Улс, Дархан Уул аймаг, Шарын
гол сум, Санжит баг
Утас: +976 – 13743-2246
Факс: +976 - 13743 -2235

Удирдлагын төв оффис:

Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө-13,
1-р хороо, Натур Тур ХХК-ний байр
4 давхарт
Утас: +976 – 11 - 311073 / 7010 0217
Факс: +976 - 11 - 311 074 / 310 216
E-mail: mail@sharyngol.com

1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|--|
| Компанийн оноосон нэр: | “Шарын Гол” ХК |
| Байгуулагдсан огноо: | 1965 он |
| Улсын бүртгэлийн дугаар: | 1910010009 |
| Регистрийн дугаар: | 2050374 |
| Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл: | 1498А лицензи |
| Тусгай зөвшөөрлийн хугацаа: | 2007 оны 3 дугаар сарын 16 өдөр 30 жилийн хугацаатайгаар авсан |
| Уурхайн талбайн хэмжээ: | 1827,9 гектар талбай |
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл: | Чулуун нүүрс олборлох |
| Нөөцийн хэмжээ: | Монгол Улсын Эрдэс баялгийн зөвлөлд бүртгэгдсэн (үлдэгдэл): 23,2 сая тонн |
| Нүүрсний илчлэг: | 1978 онд бүртгэгдсэнээр 3600-4000 ккал-н илчлэгтэй |

1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БАЙРШИЛ

Шарын голын нүүрсний ил уурхай нь Хэнтийн нурууны салбар Дархан уулын өвөрт далайн түвшинөөс дээш 920 м-ийн өндөрт Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос 215 км, Дархан хотоос 50 км-ийн зайтай оршино.

Зураг 1. Компанийн байршил

